


АГУУЛГА

1. МӨНХИЙН БАЯН ГАЛ ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
<i>Үйлдвэрийн байршил:</i>	2
<i>Үйлдвэрийн орчмын уур амьсгал:</i>	5
Цемент үйлвэрлэлийн явц нь:	7
2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ	8
3.1. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа	9
3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал	10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
<i>А. Архелогийн судалгаа.</i>	18
<i>Б. Палентологийн судалгаа.</i>	18
9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)	21
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТ	25
13. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад талуудад хэлэлцүүлэх хуваарь	26

1. МӨНХИЙН БАЯН ГАЛ ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж байгаа газрын засаг, захиргааны харьяалал

Үйлдвэрийн байршил: Мөнхийн баян гал цементийн үйлдвэр нь Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урагш 31 км, Сэргэлэн сумаас зүүн тийш 22 км, Налайх дүүргээс урагш 23 км-т Сэргэлэн сумын 1-р багийн нутагт, Төмөр замын 7-р зөрлөгөөс урагш /хуучин орос цэргийн ангийн хойно/ салаа төмөр замын далан дагуу цахилгаан дэд станц хүртлэх нутагт нийт 108 га талбайг хамарч оршино.



Зураг. 1 Мөнхийн баян гал үйлдвэрийн байршил

Ангилал: “Мөнхийн баян гал” боловсруулах үйлдвэр

Товч мэдээлэл:

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлт
1	Аж ахуй нэгжийн нэр	“Мөнхийн баян гал” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	9019024058
3	Регистрийн дугаар	5118115
4	Төслийн нэр	Цемент боловсруулах үйлдвэр
5	Газар ашиглах гэрчилгээний дугаар	№0340838
6	Газар ашиглах шийдвэрийн дугаар	Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2008 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн 47 тоот шийдвэр
7	Газрын хэмжээ	108 га
8	Газар ашиглах зориулалт	Үйлдвэрлэл
9	Үйлдвэрлэх түүхий эд	Портланд цемент
10	Жилд үйлдвэрлэх хүчин чадал	1 сая тонн
11	Газрын байршил	Төв аймаг Сэргэлэн сум 1 дүгээр баг
12	Үйл ажиллагаа эхэлсэн он	2015 он
13	Одоогийн байдал	2022 оны байдлаар Үйлдвэрийн шатаах зуухны хэсэгт эвдрэл гарсан тул үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогссон байна.
14	Түүхий эд	Шохойн чулуу, шар шороо, төмрийн баяжмал, байгалийн шохой, гөлтгөнө, цеолит, нүүрсний үнс
15	Ажиллах горим	03 дүгээр сараас 11-р сар хүртэл

Зорилго чиглэл: Монгол улсын болон, олон улсын шаардлага стандартыг хангасан цемент үйлдвэрлэж барилгын салбарт өсөн нэмэгдэж буй цементийн хэрэгцээний тодорхой хувийг хангаж ажиллах болон улс орны томоохон бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах зорилго тэмүүлэлтэй.



Зураг. 2 Мөнхийн баян гал үйлдвэрийн гадна байдал

Ач холбогдол: Дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хуурай аргын технологээр байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэвшилтэт технологээр баяжуулан үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх хүсэл зорилготой бөгөөд, тухайн ажлын хүрээнд байгаль орчны нарийвчласан үнэлгээ болон тухайн жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулан хариуцлагатай байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг эрхэлж, орон нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангаж ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын түүхэн товчоо: 2009 онд БНХАУ-ын улс төрийн хорооны байнгын гишүүн Монголд айлчлах үеэр Ерөнхий сайд нарын оролцоотойгоор Бүх Хятадын барилгын материал үйлдвэрлэлийн корпорацийн ТУЗ-ийн дарга болон Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд нарын цементийн үйлдвэрийн төслийн санамж бичигт гарын үсэг зурснаар энэхүү цементийн үйлдвэр барих үндэс болсон.

Манай компани нь 2007 онд цемент үйлдвэрлэж цементийн эрэлтийг бууруулах зорилгоор, нийт, 850 сая юаны хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Бид Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, 7-р зөрлөгт өдөрт хуурай аргаар 2500 тонн чулуунцар боловсруулах дамжлага бүхий жилд нэг сая тонн цемент тээрэмдэж үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтанд оруулаад байна.

Төслийг дэвшилтэд технологи, байгаль орчинд ээлтэй, чанарын өндөр баталгаатай үйлдвэрлэх технологийг мөрдөж, DCS хяналтын систем нэвтрүүлэн, сүүлийн үеийн тоос шүүх дэвшилтэт технологи ашиглаж, үйлдвэрийн энерги зарцуулалтыг хамгийн доод хэмжээнд хүрнэ.

Төсөл нь хуурай аргаар цемент үйлдвэрлэх технологи ашиглаж Улаанбаатар дахь цахилгаан станцын хаягдал үнс, төмрийн үйлдвэрийн хаягдал зэрэг материалыг хольц болгон цемент үйлдвэрлэнэ.

Үйлдвэрийн орчмын уур амьсгал:

Төв аймгийн Сэргэлэн сум орчмын уур амьсгалын төлөв байдлын үзүүлэлтүүдийг статистик аргаар боловсруулан үзэхэд агаарын температур хүйтний улиралд $-23.5^{\circ}\text{C} \dots -15.8^{\circ}\text{C}$, дулааны улиралд $+13.2^{\circ}\text{C} \dots +16.2^{\circ}\text{C}$ (1965-2013) бол хөрсний гадаргын температур өвөл $-25.0^{\circ}\text{C} \dots -16.7^{\circ}\text{C}$, зун $+18.7^{\circ}\text{C} \dots +23.7^{\circ}\text{C}$ (2000-2013). 1990 оноос хойш илэрхий дулаарсан байна. Сүүлийн 14 жилийн хугацаанд тогтвортой дулаарч эхлэх өдөр 1-2 өдрөөр эрт, хүйтэрч эхлэх өдөр илүү эрчимтэйгээр 4-5 өдрөөр хойшилсон байна. Тиймээс дулаан өдөр 5-6 өдрөөр уртассан ба дунджаар 179 өдөр байдаг байна.


Хур тунадасны жилийн хэлбэлзэл ихтэй хэдий ч ялимгүй бууралтын хандлага илэрсэн бөгөөд хур тунадас ихтэй жилдээ 280-460мм, багатай жилдээ 177-270 мм орсон. Салхины сарын дундаж хурд 1.4-3.6м/с боловч хамгийн их хурд 12.8-19.9м/с хүрдэг байна. Салхины хурд 10м/с-ээс их өдрийн тоо жилдээ 5-15. Салхины зонхилох зүг баруун, баруун хойд болон хойноос (67.4%) салхилдаг. Хаврын эхэн сараас зуны сар гарах хүртэл салхи шуурга ихтэй байдаг нь газрын гадаргын хөрсний эвдрэл, чийгийн алдагдлыг ихэсгэдэг.

Харьцангуй чийг өвөл, зун харьцангуй их 60-70% бол хавар, намартаа бага 45-50% байна. Чийгтэй өдөр бага, 31 өдөр байхад хуурай өдөр 120 байна. Цасан бүрхүүл XII-II саруудад тогтвортой тогтдог ба мөн IV-V сард ажиглагддаг бөгөөд цас ихтэй жилдээ 140-160 хоног, бага жилдээ 85-92 өдөр цасан бүрхүүл тогтдог байна.

Явган болон шороон шуурга харьцангуй бага (жилдээ 10 орчим) ажиглагдах боловч сүүлийн жилүүдэд илэрхий өсөх хандлага ажиглагдсан (2012 онд 25 удаа) байна. Цөлжилт илэрсэн байдлын зэрэглэлийн үнэлгээний үр дүнгээс харахад ихэнх нутгаар цөлжилтийн илрэл сул байгаа ч нутгийн баруун хойд хэсгээр “нэн хүчтэй” цөлжилт явагдаж байна. Ургамал бүрхүүлийн хувьд сийрэг, ургамлын био масс багатай (0.35-аасбага) байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн 2040 он хүртэлх ирээдүйн хандлагаас энэхүү Сэргэлэн сум орчмоор $1.4-2.48^{\circ}\text{C}$ дулаарч, хур тунадас 29 мм хүртэлх хэмжээгээр буурна гэсэн үр дүн гарч байна.

Үйлдвэрийн технологийг товч танилцуулга:



Цемент үйлвэрлэлийн явц нь:

Бэлэн бүтээгдэхүүний шохой, холимог материал /нүүрсний үнс зэрэг нунтаг материалыг шууд нунтаглагчинд хийх/ зэргийг зохих харьцаатайгаар найруулсаны дараа ремень машин өргөгчөөр тогтмол урсгал хэмжигч агуулахад оруулж бяцална. Ингээд дахин өргөгч машинаар V маркийн ангилан хуваагч төхөөрөмжид оруулах ба V маркийн ангилагчаас гарсаны дараа бүдүүн ширхэгтэй нунтаг нь агуулахад буцаагдаж, 2 дахь удаагийн бяцлалтад орно. Харин нарийн нунтаг нь агаарын урсгалтай хамт нунтаглагч газар хүргэгдэнэ. Нунтаглагчаас гарсан түүхий эд нь өргөгч налуу саваар дамжин өндөр үр ашиг бүхий нунтаглагч аппаратанд хүргэгдэж, эндээс сонгогдон гаргасан бүдүүн нунтаг нь налуу сувгаар дамжиж нунтаглагч аппаратанд дахин хүргэгдэнэ. Цементийн тээрийн гадаад байдлыг дээрх зурагт үзүүлээ.

Цементийн нарийн нунтаг нь хийн урсгалтай хамт өндөр нягтралтай тоос хураагчийн дотор орох ба энд хүлээж авсан тоос нь бэлэн бүтээгдэхүүн болж, агаар дамжуулагч налуу саваар цементийн агуулахад хүргэгдэнэ. Хий гаргагч хайрцаг цэвэрлэгч уут нь тоос хураагчаар цэвэршсэн хийг агааржуулагчаар дамжуулан гадагш хаяна.

Эцсийн бүтээгдэхүүн буюу цемент хадгалах агуулах

Цементийг 12 м голчтой 26м өндөртэй босоо цилиндр 4 ширхэг агуулахад хадгалах ба тэр нь ган хавтан бүтээцтэй бөгөөд 1нь 32 маркийн цемент, нөгөө 3 нь 42.5 маркийн цемент хадгалах багтаамжтай, цементийн нийт ашигтай багтаамж $4 \times 3600 = 14\ 400$ тн, нийт хадгалалтын хугацаа 3.46 өдөр байна.

ЗУРАГ 3. ЦЕМЕНТ ХАДГАЛАХ АГУУЛАХ

Цементийн агуулахад түүхий эд нягтруулагч конус хэлбэрийн өрөө болон хийлэгч аппарат байх ба хийг сэнсээр хангадаг. Цемент нь агуулахын ёроол дахь түүхий эд буулгагч хайрцаг, цахилгаан автомат хаалт, цахилгаан хяналтын хаалт, агаар дамжуулагч налуу хайрцаггаар дамжин задгай савлах агуулах буюу цемент савлагч тасгийн өргөгчинд хүргэгдэнэ.

Цемент задгай савлах агуулах

Энд 2 ширхэг 10м голчтой 20м өндөртэй, ган хавтан бүтээцтэй задгай савлах агуулах байх ба агуулах тус бүр РС32.5 холимог цемент болон РО42.5 ердийн цементийг хадгалах зориулалттай. Цементийн хадгалах хэмжээ 1500 тн, агуулахын ёроолд задгай савлах төхөөрөмжтэй. Задгай савлагчийн дээд талд түүхий эдийн хэмжээ шалгагч аппараттай, машин дүүрэхээр автоматаар түүхий эд буулгахаа зогсоодог байна.

Цемент савалгаа болон бэлэн бүтээгдэхүүн тээвэрлэх

Цементийн савлагаа нь 4 ширхэг 8 хошуутай эргэдэг боодлын машинтай. Машин бүр цагт 90-100 тн бүтээгдэхүүн савладаг. Цементийн агуулахаас ирсэн цемент нь налуу хайрцагар дамжиж шигшүүр, голын агуулах, агуулахын ёроол дахь автомат хаагч, босоо хэлбэрийн давхар хуваариллагч хаалт зэргээр дамжиж баглаа боодлын машинд орно. Багласан цемент нь ремён машин боодол шалгагч, бяцлагч зам, электрон хянагчаар дамжиж бэлэн бүтээгдэхүүний агуулахад хүргэгдэнэ. Автомат савалгааны систем нь шууд ачигдаж үйлдвэрээс гарах боломжтой.

Бэлэн бүтээгдэхүүний агуулахын хэмжээ нь 80м x 130м=10 400м², цементийн хадгалалт 14 560 тн, хадгалалтын хугацаа 3.49 хоног байна. Тус хадгалалтын хугацаа нь цемент үйлдвэрээс гарах хянан шалгалтын хугацааны шаардлагыг хангана.

2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлж, тайланд тусгав.

Европын Шинэчлэл ба Хөгжлийн банкнаас гаргасан аргачлалын дагуу цементийн үйлдвэрийн “байгаль орчинд үзүүлэх эрсдэл, хариуцлагын хүчин зүйл”-ийг доорхи байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Түүхий эдийн агуулах ба шатаах зуухнаас үүсэх тоос, түүний тархалт
- Уурын зуухнаас үүсэх хий ба тортог
- Тоос, дуу чимээ, цахиурлаг материалтай холбоотойгоор үүсэх хүний эрүүл мэнд ба аюулгүй байдлын асуудлууд
- Цементийн тээвэрлэлт ба савлагаанаас үүсэх нөлөөллүүд
- Төлбөр ба торгуулиуд (агаарын бохирдол, шингэн ба хатуу хаягдал үүсгэсэн)

Цементийн үйлдвэрээс байгаль орчинд үзүүлэх **ГОЛ НӨЛӨӨЛӨЛ** нь тоос ба хатуу жижиг хэсгүүд бөгөөд хамгийн гол сөрөг нөлөөллийг 10 микроноос бага хэмжээтэй хатуу жижиг хэсгүүд үзүүлнэ. Энэ нь хүний уушиг болон амьсгалын эрхтэнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болно.

Магадлан жагсаах арга

Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу **хяналтын хуудасны аргыг** өргөн хэрэглэдэг. Магадлан жагсаах арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Нөлөөллийн хэлбэр, шууд, шууд бус эсэх, дараалал, буцалттай, буцалтгүй эсэх, хугацаа зэргийг магадлан жагсаах аргыг (checklist) ашиглан тодорхойлов. Р. Мижиддорж нар байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд магадлан жагсаах аргыг ашиглах 2 хувилбарыг нэгтгэсэн байдлаар боловсруулсан байдаг /Р. Мижиддорж, 2002 он/. Үүнд:

1. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал. Энд экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудал, бусад асуудал гэсэн хэсэгт хамаарах нөлөөллийн хэлбэр (шууд, шууд бус), хугацаа (богино болон урт хугацааны) харуулсан магадлах жагсаалтыг нэрлэж болно.

2. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой нөлөөллийн магадлах жагсаалт. Үүнд: төслийн байршил, уг төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой нөлөөлөл, мөн барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал, төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуур буюу бодлогын чанартай асуудалд хамаарах үйлдвэр аж ахуйн газрын нөлөөллийн эрчмийг заах явдал юм.

3.1. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа
“Чулуунцар боловсруулж хуурай аргаар цемент үйлдвэрлэх” төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөл нь экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны төлөв байдлын чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх болон түүх соёлын дурсгалт зүйлс, археологи палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудлууд болон нөлөөллийн бусад хэсгүүдийг хамруулан шууд, шууд бус, богино болон урт хугацааны, эрчимшлийн хувьд хүчтэй, дунд болон бага гэх мэтчилэн ангилж магадлан жагсаах аргаар үнэлэн хүснэгт 3.1-т харуулав

3. БОЛЗОШГУЙ НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ НЬ НӨЛӨӨЛЛИЙН ТӨРӨЛТЭЙ УЯЛДАХ БАЙДАЛ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх усны нөөцийн өөрчлөлт	x				x		x		x	
Гадаргын усны нөөцийн өөрчлөлт		x			x		x		x	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							
2.Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг	x				x		x	x		
Бэлчээрийн байдал	x				x	x				
Эрдэс түүхий эдийн нөөц	x									
Эрчим хүчний нөөц		x			x					x
3.Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газар доорхи усны чанарын өөрчлөлт	x				x	x				x
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x	x			x	
Агаарын бохирдол		x		x		x				x
Хөрсний бохирдол	x			x		x			x	
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө		x		x		x				x
4.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x		x	

Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		x								x
5.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x	x			x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x	x			x	
Ажлын байр нэмэгдэх	x				x	x			x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх			x							
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x				x
6.Бусад нөлөөлөл										
Ажлын нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	x			x			x			x
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих, хөрс бохирдох		x		x			x			x
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга		x		x		x				x
Дүн	14	10	2	7	15	11	10	2	10	10

4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /сая. төг/	Нийт зардал /сая. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар						
Тоосжилт, дуу шуугиан үүсэж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Дуу чимээ, тоосжилттой ажлын байранд ажиллах ажиллагсдыг маск, иж бүрэн хувцас, чихний бөглөө, нүдний шил зэрэг хамгаалах хувцас хэрэгслээр хангах	Үйлдвэрийн ажилчидад	2023 оны Үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөнд тусгана.		2023 он	MNS (ISO) 13994:2003 Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага . MNS 5010-2001 Тоос Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
	Үйлдвэрлэлийн орчны агаарын чанарыг хэмжих багаж суурилуулах, Мэргэжлийн байгууллагаар хэмжилт мониторинг хийх,	Үйлдвэрийн талбайд	350.0	3.5 сая	Оргил үйлдвэрлэлийн үед	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд
Тээврийн хэрэгсэл болон хөдөлгүүрээс үүсэх хорт хий, утаа тоосны ялгарах	Түүхий эд, материалыг тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг бууруулах үүднээс засвар үйлчилгээг тогтмол хийх, тогтоосон маршрутаар тээвэр хийх тухай тээврийн гэрээнд тусгах	Түүхий эд, материалыг тээвэрлэх тээврийн хэрэгслүүд	Гэрээт тээвэрлэгч байгууллага хариуцана		2023 оны туршид	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /сая. төг/	Нийт зардал /сая. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны чанар						
Гадаргын болон гүний ус бохирдох	Бохир ус цэвэрлэгээний байгууламжийн үйл ажиллагааг хэвийн горимд үе шаттай шилжүүлэх, гүний болон хаягдал усны чанарын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гүний худагууд болон цэвэрлэх байгууламжууд	Нэг удаагийнх 1.0 сая.төг Жилд 4.0 сая.төг	20.0	2023 он Улиралд 1 удаа	Монгол улсын хаягдал усны MNS4943:2014 стандарт - MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга.
Байгалийн усны нөөц ашиглах, хамгаалах	Усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх	Бүх худгууд дээр	Ашигласан усны хэмжээг буюу тоолуурын дүнгээр тооцно..		2023 жилийн турш	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль -2012.05.17

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /сая. төг/	Нийт зардал /сая. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ургамлан нөмрөг						
Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг жилд 1-2 удаа явуулж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбай болон орчны бүсэд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.		2023 он Жилд 1-2 удаа	- Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546:2005 Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал, аргазүйг баримтална.
Ашиглалтын талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах	Үйлдвэрийн талбайд	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.		Жил бүр	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008
Хөрсөн бүрхэвч						
Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг ил задгай хаях	Хог хаягдлын нэгдсэн цэгийг тохижуулах	Үйлдвэрийн одоо байгаа хогын цэгт	10.0	10.0	2023	Хог хаягдлын тухай хууль Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага MNS 5344:2003
Түүхий эдийн тээврийн 8 км зам нь орчны тоосжилт үүсгэх	Хуурайшилттай нөхцөлд усалгаа хийх, Зам засварын ажлыг гүйцэтгэх	Тээврийн зам, үйлдвэрийн тоосжил бүхий хэсэг	Дотоод санхүүжилтээр		2023 он	MNS,ISO 4227: 2002 MNS 0017-2-0-07:1979 MNS 0017-2-1-01 : 1978 MNS 4585:2007

Амьтны аймаг					
Үйлдвэрийн болон орчны талбай дахь амьтны аймаг нөлөөлөлд өртөх	Амьтны мониторинг судалгааг жилд 1-2 удаа явуулж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбай болон орчны бүсэд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгах.	2023 он	Амьтан судлаачдын зөвлөмж, тусгай боловсруулсан арга зүй

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /сая. төг/	Нийт зардал /сая. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ						
Хүний эрүүл мэнд	Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Үйлдвэрийн ажилчидад	1 удаа: 6.9 Жилд: 13.8.	69,0	Жилд 1-2	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000 - Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13688:2000 Гал түймрээс хамгаалах. MNS 5566-2005
	Ажлын байранд анхан шатны тусламж үйлчилгээний иж бүрэн багаж хэрэгслийг авч, байрлуулах.	Үйлдвэрийн байр, удирдлага, ажилтнуудын байр	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төсөвт оруулсан		2023 он жилд 1 удаа	
	Ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	Бүх ажиллагсад			Сар бүр 1-2 удаа	
Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	20.0	40.0	2 жил тутамд 1 удаа 2023 он	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйл.
	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх		15.0	15.0	5 жил тутам 1 удаа	Газрын тухай хуулийн 58.5-р зүйл. ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоол- Газрын төлөв байдал, чанарын улсын

					хянан баталгаа хийх журам
	Жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах		Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
Орон нутагтай хамтран ажиллах	Хяналт шинжилгээний үр дүнгүүдийг орон нутгийн захиргаа, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэдний саналыг авах	Орон нутаг хамтын ажиллагааны хүрээнд		11-12 сар	
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ /сая.төг/			2023 оны зардал: 53.500 сая.төг		

5. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /сая. төг/	Нийт зардал /сая. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны чанар						
Төсөл хэрэгжих газрын байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор мод тарьж ногоон байгууламжийг өргөтгөн байгуулах	Мод тарих /хайлаас, буйлс, улиас/	Эзэмшлийн газрын 10%-иас багагүй талбай буюу 10.8 га талбай* Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 2 га талбайд мод тарих	1 га-д тарих модны тоо 3000 ш суулгац 15 га * 3000ш = 45000 ш суулгац 1суулгацы н дундаж үнэ 6000 төгрөг**	36.0	2023 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл.
НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН:				2023 оны зардал: 36 сая.төг		

6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийг хэрэгжүүлэх явцад биологийн олон янз байдалд эргэн нөхөн сэргэхээргүй сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй учраас биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслөөс орон нутгийн иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих орчны түүх, соёлын өв дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

А. Архелогийн судалгаа. Цементийн үйлдвэрийн орчим нь улсын чанартай авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам зэрэгт холбогдсон дэд бүтэц сайтар хөгжсөн бүс нутаг бөгөөд эртнээс эхлэн хүн тасралтгүй орших амьдарч байсан нутаг учир эртний түүх, архелогийн хайгуул судалгааны ажил хийгдээгүй учир Монгол улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалттай түүх, архелогийн томоохон дурсгал бүртгэгдээгүй байна. Иймд түүхийн олон үеийн дурсгал байх магадлалтай хэдий ч уг газар нь намагтай, цэвдэг бүхий бамбалзуур хөрстэй байгаа нь дурсгал байх магадлалыг багасгаж байна. Судалгааны үр дүнд ямар нэгэн түүх архелогийн дурсгал илрээгүй болно.

Б. Палентологийн судалгаа. Төсөл хэрэгжих талбайд явуулсан палеонтологийн хайгуул, тандан судалгааны үр дүнд палеонтологийнолдвор эртний амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл илрээгүй болно. Гэсэн хэдий ч энэ талбайд тархсан девоны настай Горхи формацын улаан хасын үеүд нь микро амьтны үлдэгдэл радиоляр элбэгтэй бөгөөд түүнд силур-девоны цаг үеийн радиолярын 4 цогцолборыг ялгаж, хурдсын насыг нарийвчлан тогтоож байсан стратиграфийн ач холбогдолтой зүсэлтүүдтэй дүүрэгт тус цементийн үйлдвэрийн талбай хамаарагддаг тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай. Бидний судалгаагаар одоогоор цементийн үйлдвэр нь доод девоны Сэргэлэн формацын ногоон занарын зузаалаг дээр байрлаж байгаа нь тогтоогдсон тул палеонтологийн талаас нөлөөлөх зүйлгүй юм.

В. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан.

9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт зардал /мянга, төгрөг/	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны сургалт	Лабораторын химийн бодистой ажилладаг ажилчид	2023 оны 02-р улиралд	500.000	БОХАБЭА-н хэлтэс,	Химийн бодистой ажилладаг ажилчид хор аюулын мэдлэгтэй болох	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
2	Хүчил шүлтэнд тэсвэртэй тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангах	Химийн бодистой ажилладаг ажилчид	Лаборатор ажиллаж буй бүх нөхцөлд	Үйлдвэрийн урсгал засварт тусгагдсан	БОХАБЭА-н хэлтэс,	Тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг тогтсон стандартаар хангаж ажиллах	“Химийн хорт болон аюулгүй бодисын тухай” хуулийн 13-р зүйл
3	Химийн хорт болон аюулгүй бодисын хог хаягдлыг устгах	Лабораторт хэрэглэгддэг хортой аюултай бодисууд	Жилд 2 удаа	1.500 00	БОХАБЭА-н хэлтэс, Мэргэжлийн байгууллага	Химийн хортой хог хаягдлыг бүртгэж, устгах акт хөтлөх	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10-р зүйл
4	Химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, болзошгүй аюулын үед аврах баг бэлтгэх	Үйлдвэрийн бүх ажилчид	2023 оны улирал тутам	Үйлдвэрийн урсгал зардалд тусгасан	Үйлдвэрийн захиргаа, БОХАБЭА-н хэлтэс	Химийн хорт бодистой агуулахын аюулгүй байдал хамгаалалтыг сайжруулах, гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль “Гамшигаас хамгаалах тухай хууль”
5	Химийн бодистой харьцах үеийн өдөр тутмын зааварчилгаа, Давтан зааварчилгаа	Лабораторт ажиллаж буй бүх ажилчид	2023 оны турш тогтмол	Үйлдвэрийн урсгал зардалд тусгасан	БОХАБЭА-н хэлтэс мэргэжлийн байгууллага хамтран хэрэгжүүлнэ	Танхимийн болон ажлын байран дээрх зааварчилгаа, БОХАБЭА-н дарга хяналт тавина.	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, сая.төг	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Хөрс, ус, агаарын бохирдол. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх	Хог хаягдлын зэрэглэлийг тогтоолгох	Төслийн хэмжээнд	2.0	2.0	2023 он	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал
	Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс жилд үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг нарийвчлан тогтоох	Төслийн хэмжээнд	1.0	1.0	3 жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/368 дугаар тушаал
	Ажиллагсдад хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах	“Мөнхийн баянгал” ХХК-ийн бүх ажиллагсад	0.5	1.0	2023он 2удаа	Хог хаягдлын тухай хууль
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ /сая.төг/				2023 оны нийт зардал: 4.0 сая.төг		

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааг тусгасан удирдамж юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор ОХШХ-т тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /сая.төг/		Баримтлах стандарт ба арга, аргачлал
						Нэг жилд	5 жилд 2022-2026	
Агаарын чанар								
- Хүхэрлэг хий (SO2) - Азотын ислүүд (NOx) - PM 2.5 - PM10 - TSP нийт тоос - Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	мкг/м ³	1. Үйлдвэрийн талбай дотор 2. Үйлдвэр руу зорчих шороон замын дагуу	Гадаад орчны агаарын чанарын судалгааг жилд 4 удаа	Гадаад орчны шинжилгээнд 5 цэгээс дээж авах.	29.5* 32.5* 25.0* 25.0* 28.5* Нэг удаа: 165.5	3.31	16.55	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох


Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /сая.төг/		Баримтлах стандарт ба арга, аргачлал
						Нэг жилд	5 жилд 2022-2026	
								фотоколориметрийн арга,
Хөрсний төлөв байдал, чанар								
- Хөрсний орчин - Ялзмагийн агууламж мг/кг - Карбонатын агууламж - Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн - Хүнд металлын агууламж	Мг/кг	1. Ажилчдын байрны хашаан дотор 2. Хашаанаас хойд зүгт 300 метр, 3. Хашаанаас зүүн тийш 500 м	Жилд 2 удаа	Нэг удаагийн шинжилгээнд мониторингийн 3 цэгээс дээж авч шинжлүүлнэ.	Үндсэн шинжилгээ: 40.0 Хүнд металл: 50.0	0.54	2.7	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /сая.төг/		Баримтлах стандарт ба арга, аргачлал
						Нэг жилд	5 жилд 2022-2026	
								лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
Усны чанар								
Усны чанарын судалгаа - Усны орчин рН - Эрдсийн бүрэлдэхүүн - Хүнд металлын агууламж - Микробиологи		Хиймэл нуур 1 Гүний худаг 7	Жилд 2 удаа	Улирлын горимоор мониторингийн цэгээс усны дээж авч судлах	Хүнд металлын шинжилгээ- 50.0 Ерөнхий үзүүлэлт*-72.0 Микробиологи: 30.0	2.432	12.16	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /сая.төг/		Баримтлах стандарт ба арга, аргачлал
						Нэг жилд	5 жилд 2022-2026	
								шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Амьтны аймаг								
Амьтны аймгийн судалгаа	Шавж, шувуу, хөхтөн	Төслийн талбай болон түүний орчимд	Жилд 2 удаа	Улирлын горимоор мониторингийн судалгаа хийх	1000.0	2.0	10.0	Амьтан судлаач, мэргэжилтнүүдийн зөвлөмж
Ургамлан нөмрөг								
Ургамлын судалгаа		Төслийн талбай болон түүний орчимд	Жилд 2 удаа	Улирлын горимоор мониторингийн судалгаа хийх	1000.0	2.0	10.0	Ургамал судлаач, мэргэжилтнүүдийн зөвлөмж
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН /сая.төг/						2022-2026 оны нийт зардал: 51.41 сая.төг 2023 оны зардал: 10.282 сая.төг		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТ

“ Мөнхийн баян гал ХХК-ийн захирлын тушаалаар компанийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан инженер томилж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг компани захиргааны өмнө хариуцна. Байгаль орчны асуудал хариуцсан төр захиргааны бүх шатны байгууллагын өмнө дээрх хариуцлагыг компаний ерөнхий захирал хариуцлага хүлээнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг уялдаа холбоог графикаар үзүүлэв.



13. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад талуудад хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОАЖЯам	Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган БОАЖЯ-нд хүргүүлнэ.	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, гүйцэтгэл	Жил бүрийн 12 дугаар сард	БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч дүгнэлт гаргаж, дараагийн жилд хэрэгжүүлэх БОМТ-г хянан батална.	“Мөнхийн баянгал” ХХК
Төсөл хэрэгжих сумын Засаг дарга, Багийн Засаг дарга	Хагас жилийн тайланг хүргүүлж, санал авах	Төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Хагас жил тутам	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилт	
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч					
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн багийн ИНХ	Танилцуулга хийх	БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулга	Хагас жил тутамд	БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулж, санал авах	
Иргэд, олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал хүсэлт хүлээн авч, төсөлтэй холбогдох гомдлыг шийдвэрлэж, барагдуулах	Байгаль орчны талаар гаргасан санал, гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн	Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд	Сонирхогч, оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	